

УЛС ТӨРИЙН ГАЗРЫН ЗУРГИЙН ИРЭЭДҮЙ

*Параг Ханна**

Бид хил хязгааргүй дэлхий дээр амьдардаг гэж үү? Та бүхэн хариултынхаа өмнө энэхүү газрын зургийг харцгаана уу. Энэхүү газрын зураг дээр өнөөдрийн байдлаар 200 гаруй улс оршин байгааг харуулжээ. Өнгөрөгч зуунуудаас магадгүй илүү юм. Яг одоо та бүхний олонхи нь үүнтэй санал нийлэхгүй биз. Танд энэхүү газрын зураг санаанд тань буух байх. Тэгвэл та үүнийг ТЭДистан хэмээн нэрийдэж болно. ТЭдистаны хувьд ямарваа нэг хил хязгаар үгүй бөгөөд зүгээр л холбогдсон болон холбогдоогүй орон зай юм. Магадгүй бид нарын ихэнх нь энэхүү дэлгэцэн дээр харагдаж байгаа дэлхийн эдийн засгийн төвүүдийн 40 цэгийн аль нэгэнд л оршиж байгаа байх. Гэтэл олонхи хэсэг нь дэлхийн эдийн засгийн 90%-ийг төлөөлдөг.

Мэдээж олонхи нь уугуул газар орондоо байсаар л байгаа 90%-ийн тухай авч үзье. Тэдний хувьд хил хязгаар улс үндэстэн зэрэг нь их ач холбогдолтой зүйл юм. Одоо энд ТЭД-д ертөнц болон шинжлэх ухаан агуу нууцлаг тааврыг тайлах гэж байна. Бидний тайлж чадаагүй асуудал бол манай улс төрийн газар зүй юм. Өөрсдийгөө дэлхий даяар хэрхэн хуваарилдаг юм бол?

Энэ бол чухал асуудал, учир нь хилийн зөрчилдөөн нь дэлхийн цэргийн хүч аж үйлдвэрийн цогцолборын ихэнх хэсгийг тодорхойлдог юм. Хилийн зөрчил нь бидний хүрэхээр найдаж байгаа ихэнх хэсгийг үгүй болгож болно. Иймд бид хүмүүс эрх мэдэл, шашин, соёл, технологийн дэлхийн газрын зургийн өөрчлөлт хэрхэн харилцан нөлөөлдөг вэ гэдгийг илүү гүнзгий ойлгох хэрэгтэй болов уу гэж бодно. Ингэснээр бид тэдгээр өөрчлөлтүүдийг урьдчилан мэдэж, илүү үр бүтээлтэй замнал руу хүргэх тухай бодож болно.

Иймээс бид өнгөрсөн өнөөдөр хоёрын газрын зураг, юмс хаашаа чиглэж буйг ойлгох тухайд урьд өмнө хэзээ ч харж байгаагүй газрын зургийг харах гэж байна. Тэгэхээр 1945 оны дэлхийн байдлаас эхлэе. 1945 оны үесд дэлхий дээр ердөө 100 гаруй улс оршин тогтнож байжээ. Гэвч далайн чанадад Францын эзэмшил дэх Баруун Африк, Британий эзэмшил дэх Зүүн Африк, Өмнөд Африк гэх мэтчилэн колоничлолын газар нутаг хэвээр байв. Дараа нь 40 оны сүүл, 50, 60, 70 болон 80-аад онуудад колоничлолыг халах үйл явц өрнөсөн. Эндээс шинээр 50 гаруй улс үүссэн. Та бүхэн Африк задарсан байгааг харж болно. Энэтхэг, Пакистан, Бангладеш, Зүүн өмнөд Азийн улсууд бий болсон. Тэгэж байтал хүйтэн дайны төгсгөл ирсэн. Хүйтэн дайны төгсгөл болж Зөвлөлт Холбоот Улсын задрал эхэлсэн. Та бүхэн Зүүн европийн шинэ улсууд хуучин Югослав, БНУлсууд, “Төв Азийн стан” улсуудыг харлаа.

* Параг Ханна - улс төр судлаач, шинжээч

Өнөөдөр тэгвэл 200 гаруй улс бий болжээ. Дэлхий маань тусгаар тогтносон улс үндэстэнээр нэмэгдсэнийг харж болно. Энэ нь зарим нэгнийх нь хожил өөр нэгнийх нь хувьд хохирол болсон гэсэн үг үү? Дэлхийн стратегийн хувьд хамгийн чухал газар болох Зүүн Евроазийг тойруулан харцгаая. Та бид энэ газрын зураг дээрхийг харж байгаачилан Орос улс дэлхийн хамгийн том газар нутагтай хэвээрээ байна. Бас та бүхний мэдэж байгаагаар Хятад хамгийн их хүн амтай улс тэдгээр нь маш урт хилийн бүсэд тархан байрласан.

Харин энэ газрын зургаас юуг олж харж чадахгүй байна вэ. Энэ бол Оросын 150 сая хүн амын ихэнх нь Европтой илүү ойр баруун мужуудад төвлөрсөн байхад, 30 гаруй сая хүн нь зүүн хэсгийн газар оронд төвлөрөх аж. Үнэн хэрэгтээ Дэлхийн банк оросын хүн ам 120 сая болж буурна хэмээн урьдчилан тааварласан.

Бас энэ газрын зураг дээр олж харагдахгүй нэг зүйл бол Сталин, Хрущев болон зөвлөлтийн бусад удирдагчид ард иргэдээ алс дорнод руу цөлж ажлын лагер болон цөмийн хот бүс рүүгээ ямар ч аргаар юм албадан гаргадаг байжээ. Гэвч газрын тосны үнэ өссөнөөр Оросын засгийн газар зүүн баруун газар нутгаа нэгтгэхээр дэд бүтэцдээ хөрөнгө оруулалт хийж байна. Гэвч юу ч Оросын хүн ам зүйн тархалтыг муутгахаас илүү чадаагүй. Учир нь хэзээ ч амьдрахыг үл хүсэх алс дорнодод хүн зон нь харин ч тэрхүү галт тэрэг засмал замаар нь эргээд харихыг эрмэлзэнэ. Эндээс Энэтхэгээс хоёр дахин том газар нутагтай Оросын Алс дорнодод яг одоо 6-хан сая оросууд амьдарч байна.

Ингэхээр дэлхийн энэ хэсэгт юу болж байгаа талаар ойлголт авцгаая. Бид Монгол Улс эсвэл зарим нэгнийх нь нэрлэж байгаагаар “Маингол”-оос эхэлж болно. Тэд яагаад ингэж нэрлэх болов. Маин гэдэг нь уул уурхай гэсэн үг бөгөөд Монгол Улсыг уул уурхайн эх орон гэдгээр нь мэддэг болсон. Учир нь Маинголиа-д Хятадын компаниуд зэс, цайр, алт гэх мэт ихэнх орд газруудыг эзэмшин олборлолт явуулан хойд болон зүүн урд газраар нь гаргадаг байна. Хятад улс Монголыг эзэлж аваагүй. Харин худалдаж авч байна. Колониуд нэгэн цагт эзлэгдэж байсан бол өнөөдөр улс орнууд худалдагддаг, зарагддаг болжээ.

Иймд одоо энэхүү зарчмыг Сибирьтэй холбон авч үзье. Сибирь гэхээр та бидний төсөөлөлд хүйтэн сэрүүн хүн, амьдрах боломжгүй зэлүүд газар гэж буудаг. Гэвч үнэндээ дэлхийн дулаарлын уршигаар гэнэтхэн тарилангийн талбай, агробизнес хүчээ авч цэцэглэх болов. Энэ нь хэний хэрэгцээнд зориулагдах вэ? Амо голын нөгөө эрэгт 100 сая хүн амтай Хэйлунжян муж, Харбин хот байж байна. Энэ нь оросын хүн амтай харьцуулашгүй их юм.

Жил бүр тэдний хамгийн багадаа 10 мянга, 60 мянган хүмүүс бүтээсэй хэмээн залбиран энэхүү алс бөглүү өмнөд рүү дүрвэн амьдрах хүсэлтээ илэрхийлсээр байгаа юм. Тэд өөрсдийн зах, дэлгүүр, эрүүл

мэндийн төвүүд, сувиллын газруудыг байгуулдаг. Тэд модны үйлдвэрлэлийг эрх мэдэлдээ аван зүүн нутгаар дамжуулан Хятадруу гаргасаар л байна. Дахин хэлэхэд Монгол шиг Хятад улс оросыг эзэлж аваагүй, зүгээр л түрээсэлж байгаа юм. Үүнийг л би Хятад маягийн глобалчлал хэмээн нэрийдээд байгаа юм.

Энэ бол одоогоос 10-20 жилийн дараа бүсийн газрын зураг ямар болохыг харуулж байна. Гэхдээ хүлээж байгаараа энэ бол одоогоос 700 жилийн тэртээх газрын зураг юм. Энэ нь Чингис хааны ач хүү Хубилай хааны удирдаж байсан Юан улсын газрын зураг. Иймээс түүх яг таг давтагддаггүй ч эргэх холбоотой байдаг юм.

Энэ бүхнийг би дэлхийн энэ хэсэгт юу болж байгааг тодруулахын тулд тайлбарлалаа. Дахин хэлье хятад маягийн глобалчлал. Учир нь глобалчлал бидэнд улс төрийн газар зүйг өөрчлөх мөн ухаж ойлгох, бүх төрлийн замыг нээж өгдөг. Иймд Зүүн Азийн түүхийн тухай үндэстэн юм уу хил хязгаарын тухай боддоггүй. Хүмүүс ихэвчлэн эзэнт гүрний байлдан дагуулал, захирах захирагдах ёсны тухай, гол төлөв Хятад эсвэл Япончуудын тухай мэдлэг мэдээллээр төсөөлдөг.

За тэгэхээр дахиад л Хятадын ээлж ирж байна. Тэгэхээр хятадууд тэрхүү алс дорнод хэсгийн шатлан захирах ёсыг дахин байгуулж байгааг харцгаая. Энэ нь бүх дэлхийн төвүүдээс эхэлдэг юм. Дэлхийн эдийн засгийн төвүүдийг харуулсан 40 цэгтэй шөнийн газрын зургийг санаж байна. Зүүн Азид өөр дэлхийн аль ч бусад бүсүүдээс олон дэлхийн эдийн засгийн төвүүд байдаг билээ. Үүнд: Токио, Сөүл, Бээжин, Шанхай, Хонконг, Сингапур болон Сидней хотуудыг дурдаж болно. Эдгээр төв нь дэлхийн баялгийн цул хэсгүүдийн шүүлтүүр гэсэн үг. Энэ бүсүүд нь нэг жилд л гэхэд хэдэн триллионоор нь гадаад валют олдоогоос ихэнх нь хятад руу ордог.

Энд худалдааны зураглал харагдаж байна. Эдгээр зам чиглэл болон сум нь бүс нутгийн бүхий л улсууд нь Хятадтай худалдааны далайцтай харилцаа тогтоосныг харуулж байна. Ялангуяа энэ нь АНУ-ын хамгийн хүчтэй холбоотон болох Япон, Солонгос, Австралийг үзүүлж байна. Тухайлбал Австрали улс төмрийн хүдэр, байгалийн хийн экспортоор Хятадаас хамааралтай. Ядуу улс орнуудад Хятад үнийн саналаа хямдруулснаар Лаос, Камбужид бараагаа арай хямд худалдах боломжтой болсноор Хятадаас экспортын хамааралтай болдог байна.

Та бүхний ихэнх нь орчин үеийн мэдээллээс хүмүүс хэрхэн Хятад, зөвхөн Азид бус ер нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг тэргүүлэхийг харж, уншиж байгаа байх. Азийн худалдааны чөлөөт бүс Номхон далайн нийт худалдаанаас илүү байна. Иймд Хятад улс нь бүс нутгийнхаа эдийн засгийн занга нь болж байна.

Стратегийн нэг тулгуур бол дипломат байдал юм. Хятад улс бүсийнхээ олон оронтой цэргийн хүчний гэрээ байгуулсан. Жишээ нь Зүүн Азийн холбоо гэх мэт дипломат ажиллагааны төв болсон юм.

Улс орнуудын хооронд үл довтолх гэрээ хэлэлцээр гэж байдаг. Хэдий тийм ч Хятад болон АНУ-ын хоёрын хооронд зөрчил гарвал ихэнх улсууд үүний дотор Америкийн холбоотнууд болох Солонгос, Австрали хоёр улс ажиглагч, төвийг сахисан талыг барина.

Стратегийн бас нэг тулгуур бол Оростой адил хүн ам зүйн бодлого юм. Хятадууд ажилсаг хүмүүс бөгөөд хүүхэд асрагч, оюутнууд багш нарыг хятад хэл заалгахаар цус холилдуулан, эдийн засгийн хувьд нь илүү бие даасан байдалтай болгохын тулд бүс нутагруу хүмүүсээ экспортлодог байна. Малайз, Тайланд, Индонезид байгаа хятад үндэстнүүд хэдийнээ тухайн газар орондоо эдийн засгийг мэдэгч гол хүчин болсон байна. Хятадын бахархал нь тухайн суурьшсан газартаа дараагийн үе удмаа залгах явдал ажээ. Сингапурт жишээ нь хятад хэлний боловсролыг зөвшөөрдөггүй байсан бол одоо дэмжих болжээ.

Хэрэв энэ бүхнийг хооронд нь нэмэхийн бол та юу олж авах вэ? Хэрэв энэ бүхнийг анзааран ухаж ойлгох юм бол, та дэлхийн II дайны өмнөх үеийг санах юм бол Япон улсын аугаа санаархал болох шинэ хөгжил цэцэглэлтийн орчин буюу нилэнхүйд нь эзлэн түрэмгийлэх бодлогыг явуулсан. Өнөөдөр юу хөгжиж байна вэ гэвэл та бүхэн магадгүй Хятадын аугаа эзэрхийлэл хэмээн нэрлэх байх.

Иймд газрын зураг дээр улс үндэстэн хил хязгаарын хувьд ямар зураас байх нь хамаагүй Ойрхи Дорнодод гэхдээ илүү хувирамтгай эзэнт улсуудын бүсүүдэд юу үүсэн бүрэлдэж байна гэвэл үндэсний соёлууд энэ бүхэн ямарч буун дуун гаргалгүй болж байна. Харин энэ бол улс гүрнүүдийн Европын колоничлогчдын үлдээсэн хилийн бүсийн түгшүүртэй оршдог Ойрхи Дорнодод ерөөсөө боломжгүй асуудал юм. Иймээс бид дэлхийн энэ хэсэгт хилийн бүсийг хэрхэн ойлгох хэрэгтэй вэ гэсэн бодол орж ирнэ. Газрын зургийн зураасны аль хэсэгт анхаарлаа аваачих вэ. Би та бүхэнд юуг тайлбарлахыг хүсэж байна гэвэл миний нэрлэдэгээр аажимаар улс оронг байгуулах.

Тэгвэл Иракаас эхлэе. АНУ Ирак улсыг эзлэн авснаас хойш даруй 6 жилийн нүүрийг үзэхэд тус улс бодитой оршиж байгаа гэхээс илүүтэй газрын зураг дээр оршиж байна. Газрын тос Ирак улсыг нэгтгэх хүчин зүйлсийн нэг байсан цаг саяхан. Эдүгээ тус улсыг хагалж байгаа хамгийн том шалтгаан болжээ. Энэ шалтгаан нь Курдистан юм. Курдууд бүхэл бүтэн 3000 гаруй жилийн турш тусгаар тогтнолын төлөөнөө тэмцэж ирсэн бол одоо л түүнийгээ биелүүлэх боломж гарч ирээд байгаа юм. Энэ нь юу вэ гэхээр газрын тосоор баялаг бүс нутаг болох Курдистанаас эхэлсэн дамжуулах хоолойн зам юм.

Хэрэв та өнөөдөр Курдистанд очивол Курдын Пешмерга партизанууд Иракийн Суннитуудын армитай тулалдахаар зэхэж буйг харна. Гэхдээ тэд юуг хамгаалаад байна вэ? Газрын зураг дээрх хилийг хамгаалж байна уу? Үгүй юмаа дамжуулах хоолойг хамгаалж байгаа юм.

Хэрэвээ Курдуд дамжуулах хоолойг хяналтандаа байлгаж чадах юм бол төрт улс болох болзлоо хангах юм. Үүнд бид санаа тавиад байвал задарч болзошгүй болоод байгаа Иракийг яах вэ? Санаа зовинох хэрэггүй гэж бодож байна. Ирак бол Саудын Арабын дараа орох газрын тос үйлдвэрлэгч дэлхийн хоёр дахь том орон хэвээрээ үлдэнэ. Ингээд бид 3000 жил үргэлжилсэн маргааныг таслах бололцоотой болно. Курдистаныг далайд гарцгүй гэдгийг санах хэрэгтэй. Тэдэнд ажиллахаас өөр сонголтгүй. Газрын тосноосоо ашиг олохын тулд Турк болон Сири улсаар дамжуулан Ирак болон бусад улсад экспортлохоос өөр аргагүй. Тиймээс эдгээр улстай нөхөрсөг харилцаатай байх шаардлага Курдистанд тулгарана.

Харин одоо тус бүс нутгийн мөнхийн зөрчлийг авч үзье. Энэ бол мэдээж Палестин юм. Палестин бол газрын зургийн гажилт гэмээр оршин байдаг. Юу гэвэл тус улсын хоёр хэсэг нь Израильд нэг хэсэг нь Палестинд хамаардаг. 30 жилийн турш явуулсан “сарнай цэцгийн дипломат бодлого” уг зөрчлийг арилгаж энх тайванг тогтоож чадаагүй л байна. Тэгээд ямар зүйлийг тогтоож чадах бол? Миний бодлоор уг асуудлыг дэд бүтэц шийдвэрлэж чадна. Эдүгээ донор улсаас энэ салбарт долларыг хэдэн тэрбумаар нь хаяж байна. Тэр хоёр сум нь юуг харуулж байна вэ гэвэл Газ болон Баруун эргийн нутгийг хамарсан хот хоорондын төмөр зам бөгөөд бусад дэд бүтцийн нум юм.

Хэрэв Газад байнгын ажиллагаатай боомт байгуулж Баруун эрэгтэй холбож чадах юм бол амьдрах чадвар сайтай Палестин улс, Палестиний эдийн засгийг хөл дээр нь тогтооно. Энэ нь дээрх зөрчлийг арилгаж энх тайван байдлыг бий болгоно гэдэгт миний бие итгэдэг. Курдистан, Палестин хоёроос үлдэх сургамж гэвэл дэд бүтэцгүй тусгаар тогтнол дангаараа хоосон дэмий зүйл юм.

Хэрэв бид хил хязгаараас гадна газрын зураг дээрх өөр бусад шугамууд дээр анхаарлаа төвлөрүүлбэл аюултай багасах үед ямар янзтай харагдах бол? Хамгийн сүүлд сонирхол татаж нэг зууны өмнө буюу Оттоманы Эзэнт улсын үед байсан. Хижазын төмөр зам. Хижазын төмөр зам Истанбул хотоос Дамаскаар дамжин Мединад хүрдэг. Түүгээр ч зогсохгүй одооны Израильд Газрын дундад тэнгисийн эрэгт орших Хайфа хотод очих салаа замтай байлаа. Эдүгээ Хижазын төмөр зам балартжээ. Хэрэв бид газрын зураг дээрх тэдгээр тахиралдсан шугамыг шулуун шугам буюу хилээр нэвт гарсан дэд бүтэц болгож өөрчилсөн бол Ойрхи Дорнод миний бодлоор харьцангуй амар амгалан бүс нутаг байх байсан.

Одоо дэлхийн нэгэн өөр хэсэг Төв Азийн буюу Зөвлөлтийн “стан”-ыг авч үзэцгээе. Эдгээр орны хилийг Сталины зарлигаар тогтоосон билээ. Сталин хэргээр эдгээр улсыг утга учиргүй болгохыг бодоогүй. Тэрбээр хувааж захирахад хялбар байхаар үндэстэн ястнуудыг өөр хооронд нь холилдуулах хүсэлтэй байлаа. Тэдний аз болоход газрын тос, хийн ихэнх баялаг ЗХУ задран унасны дараачаар нээгдсэн билээ.

Та бүхний зарим нь газрын тос л гээд байх юм. Яагаад зөвхөн газрын тосны тухай яриад байгаа юм бэ? гэж бодож байгаа байх. Үнэн хэрэгтээ газрын тосны талаархи ойлголт ярьж байсан болоод одоо яригдаж байгаа байгаа хоёрын хооронд том ялгаа байгаа юм. Өмнө нь бид тэдний газрын тосыг яаж хяналтандаа байлгах вэ гэдэг байсан бол одоо тэд өөрсдийнхөө баялгийг өөрсдийн тусын тулд хэрхэн ашиглах асуудалтай тулгарч байгаа онцлогтой. Энэ нь тэдний хувьд колоничлогч, эзлэн түрэмгийлэгч нарын хувьд ямар чухал байсан яг тэр хэмжээгээр чухал болохыг та бүхэн ойлгоосой гэж бодож байна. Ирэх 10, 20 жилд төлөвлөж байгаа дамжуулах хоолойн төсөл боломж, зохиомж чиглэлээс заримыг авч үзэцгээе. Ийм жишээ олон байгаа.

Дэлхийн энэ хэсэгт оршдог олон орны хувьд дамжуулах хоолой тавих нь дэлхийн эдийн засагт нэвтрэн орох тийз бөгөөд тэр бүр тогтвортой байж чаддаггүй хилээс гадна өөр зарим утга учир агуулдаг. Азербайжаныг аваад үзье. Тус улс Кавказын мартагдсан хэсэг байсан боловч одоо Баку, Тбилис, Цейхан чиглэлээр Турк руу нэвтрэн дамжуулах хоолойн ачаар өөрийгөө барууны хил хэмээн сурталчилж байна.

Туркменистан улсын хувьд ихэнх нь ямарч хэрэгцээгүй гэж үздэг. Гэсэн хэдий ч тэд Каспийн тэнгисээр Европыг хийгээр хангахад хувь нэмрээ оруулж байгаа бөгөөд цаашид Туркмен, Афган, Пакистан, Энэтхэг чиглэлээр дамжуулах хоолойгоор хий нийлүүлэх боломжтой.

Тэгэхээр энэ бол Казахстан улс, өмнө нь нэр нь ч дуулддаггүй шахам байлаа. ЗХУ-ын үед үндсэндээ өмнөд Сибирьт тооцогддог байв. Харин эдүгээ ихэнх хүмүүс Казахстаныг шинэ тоглогч болохыг хүлээн зөвшөөрөөд байна. Чухам ямар учраас тэр вэ? Учир нь тус улс Каспийн тэнгисийн дагуу Оросоор дамжуулан умар зүгт, зүүн тийш Хятад руу дамжуулах хоолойг тун сүрхий төлөвлөсөн. Дамжуулах хоолой олон байх тусмаа Их тоглоомны оронд торгоны зам нэмэгдэнэ гэсэн үг. Их тоглоомны үед нэг нь нөгөөгөө ноёрхдог бол Торгоны зам төдий чинээ олон байж 21-р зуунд Их тоглоомын ноёрхлын төлөөх өрсөлдөөн тийм хэмжээгээр бага байна гэсэн үг.

Харин одоо хил хязгаараа үгүй хийж чадсан дэлхийн цорын ганц хэсэг болон тэрнийг хүч чадлаа хэрхэн бэхжүүлж чадсаныг авч үзье. Энэ бол мэдээж Европ тив. Европын Холбоо (ЕХ) анхандаа нүүрс, гангийн үйлдвэрлэл эрхэлдэг 6 улсаас бүрдэж байв. Гол зорилго нь Герман улсыг тогтвортой тайван байдлаар сэргээхэд оршиж байлаа. Гэвч яваандаа 12 улсыг бүрэлдэхүүндээ оруулж өргөжүүлж Европын Холбооны далбаан дээр 12 одоор төлөөлүүлсэн байдаг. Түүнчлэн Европын Холбоо валютын эвсэл болсны зэрэгцээ өнөөдөр дэлхийн хамгийн хүчирхэг худалдааны эвсэл болоод байгаа юм. Хүйтэн дайн дууссанаас хойш жилд дунджаар 1 улс нэгдэн орж байна. Гэвч тэдгээрийн ихэнх нь ердөө нэг л өдөр нэгдэцгээсэн юм. 2004 онд 15 улс Европын

Холбоонд шинээр нэгдэн орсон бөгөөд одоо ихэнх хүний үздэгээр 27 улс 450 сая гаруй хүнийг өөртөө нэгтгэсэн энх тайвны бүс болжээ.

Дараа нь яах вэ? ЕХ-г ямар ирээдүй хүлээж байна вэ? Гуравны хоёроос багагүй буюу худалдаа хөрөнгө оруулалтын хувьд Европын Холбооноос илүү их хамааралтай цэнхэр өнгөөр будсан бүс нутгийг бид харж байна. Энэ нь бидэнд юуг өгүүлнэ вэ? Худалдаа хөрөнгө оруулалтын байдлаас үзвэл Европ нь хаана амаа ангайна тэнд мөнгөө цутгаж байгааг мэдэж болно. Хэдийгээр эдгээр бүс нутаг Европын Холбоонд ордоггүй ч тэрний нөлөөллийн хүрээнд орж эхэлж байна. Балканы хойгийг авч үзье. Хорват, Серб, Босни улс Европын Холбооны гишүүн улс хараахан болоогүй байна. Гэсэн хэдий ч та Германы хот хоорондын хурдан галт тэргэнд суугаад бараг л Албани хүртэл аялах боломжтой. Босни улсад хэдийнээ Евро мөнгөн тэмдэгтийг хэрэглэж эхэлсэн бөгөөд цаашид ч зөвхөн энэ валютыг ашиглах төлөвтэй.

Хойд Африк гэх мэт Европын бусад зах хязгаарыг авч үзье, дунджаар нэг юм уу хоёр жил тутамд Газрын дундад тэнгисийн доор Хойд Америкийг Европ тивтэй холбосон газрын тос, хий дамжуулах хоолой шинээр байгуулагдаж байна. Энэ нь Европыг эрчим хүчний хувьд Оросоос хамаарах хамаарлыг бууруулах бөгөөд хэрэв та Хойд Африкт очих юм бол тэндхийн олон хүн өөрсдийн бүс нутгийг Ойрхи Дорнод гэж үздэггүйг мэдэх болно. Өөрөөр хэлбэл, Францын ерөнхийлөгч Саркози Газрын дундад тэнгисийн холбооны тухай ярих үед тэрнийг зөв гэдэгт миний бие итгэдэг юм.

Харин одоо Турк болон Кавказыг авч үзье. Өмнө нь Азербайжаны талаар дурьдсан билээ. Турк, Кавказын тэрхүү хонгилоор дамжуулан Европ тивийн эрчим хүчний 20%-ыг хангадаг. Тэглээ гээд Турк улс Европын Холбооны гишүүн улс болох уу? Энэ бол боломжгүй хэмээн санаж байна.

Харин түүний дараа юу болох бол? Хаана улсуудын хил хязгаар өөрчлөгдөж хаана шинээр улс орон бий болох бол доо? Төв Азийн өмнөт хэсэг, Баруун өмнөт Ази тун их тохиромжтой байршилтай. АНУ Афганистаныг эзлэн авснаас хойш даруй найман жил өнгөрсөн боловч тогтворгүй байдал хэвээр байна. Пакистан Афганистан аль алин нь пуштунчуудын үндсэрхэг үзлийг шийдвэрлэх талаар дорвитой аргыг хэрэглэхгүй байгаа нь өнөөг хүртэл эмзэг хэвээрээ л байна. Энэхүү үндсэрхэг үзэл Афган, Пакистаны хилийн хоёр талд оршин сууж байгаа 20 сая пуштунчуудын санаанд намирч буй далбаа билээ.

Бослого самууныг зөвхөн өмнө зүгээр хязгаарлахаа больё. Баличистан гэж бас байна. Балучын босогчид Пакистаны цэргийн гарнизон руу дайран орж өөрсдийн тугийг хатгасан билээ. Дэлхийн даяар колоничлолын дараахи үйл явц эрчимжиж байгаа бөгөөд миний санаагаар улс орнууд задран саринах бүрийд газрын зураг улам их өөрчлөгдөх болно.

Бид мэдээж Африк тивийг мартаж үл болно. Тус тивд 53 улс байдаг. Одоогоор газрын зурагт байгаа хамгийн их сэжиг ажиг бүхий шулуун шугамаар хиллэсэн. Африк тивийг бүхэлд нь харвал овгийн хуваагдал гэх мэт асуудлыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм. Дан ганц Суданыг авч үзье л дээ. Энэ нь Африк тивийн эхний хоёр дахь том улс бөгөөд одоо тэнд иргэний гурван дайн үргэлжилсээр байна. Та бидний мэдэж байгаачлан далдуур аймаглан устгах ажиллагаа явагдаж тус улсын Зүүн болон Өмнөт хэсэгт иргэний дайн дэгдсээр байгаа билээ. 2011 онд Өмнөд Суданд иргэний санал асуулга болох бөгөөд тусгаар тогтонолын төлөө байх нь бараг тодорхой болоод байна.

Харин одоо Хойд туйлын хүрээг авч үзэцгээе. Хойд туйлын далайн ёроолд буй эрчим хүчний баялгийн төлөө маш их өрсөлдөөн явагдаж байна. Канад, Орос, АНУ эдгээрийн аль нь амжих бол? Үнэн хэрэгтээ Гринланд ялах болно. Гринландын оршин суугчид болох 60 мянган хүн хэдэн долоо хоногийн өмнө Даниас хамааралгүй өөртөө засах эрхийн төлөө саналаа өгсөн билээ. Тийм болохоор Дани улс харьцангуй бага хувь хүртэх биз.

Энэ бүхнээс ямар сургамж авах вэ? Геополитик бол маш хатуу салбар. Энэ нь уур амьсгалын өөрчлөлттэй адил дэлхийг тасралтгүй өөрчлөн хувиргаж байдаг. Бидний экосистемтэй харьцдаг шиг бид өөрсдийгөө энэ газар нутаг дээр хэрхэн хуваарилах тэнцвэрээ ямагт эрэлхийлж байдаг. Эдүгээ бид газрын зураг дээр ямарваа нэг өөрчлөлт гарахаас айж байна. Шинэ шинэ улс орны нэр үүсэх тутам бий болдог иргэний дайн үхэл хагацлаас эмээж байна. Гэхдээ одооны хил хязгаарын эрч хүч бодсноос илүү муу тийшээ санаанд оромгүй хэрцгий болж байгаа гэж миний бие дүгнэсэн.

Тэдгээр хил хязгаарыг хэрхэн өөрчлөхөд асуудал оршиж байгаа, бид ямар шугаман дээр анхаарлаа хандуулбал зохих вэ? Миний бодлоор, хил дамнасан буюу дэд бүтцийн шугамуудад илүү анхаарах ёстой мэт. Ингэснээр бид өөрсдийн хүсч байгаа хил хязгааргүй ертөнцөө байгуулах асуудлаа шийдвэрлэх болно.

*Англи хэлнээс орчуулсан: З.Мэнд (ОУСХ-ийн
эрдэм шинжилгээний ажилтан, магистр)*